

ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл -ийн хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
<p>ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ. /“Алсын хараа-2050” зорилт 5.3, 7.4, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, 7.4, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1, Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө/</p>								
<p>Зорилт 1.Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.</p>								
1.1	Тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулах	-	Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн хувь	30		50	Тус хэлтэс нь “Бүтээлч санаачлагаар-Бүртгэлээ эрчимжүүлье” аяныг зохион байгуулж Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоны улсын бүртгэгч нар аяны хүрээнд болон Хаан банк, Төрийн банк, ЕБСургуулийн ахлах ангийн сурагчдад тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулан аймгийн хэмжээнд 1175 иргэнд тоон гарын үсэг олгосон. Аймгийн хэмжээнд тоон гарын үсэг авах 90464 иргэнээс өнгөрсөн оны тайлант хугацаанд 24372 иргэнд буюу 27%-тай байсан бол 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар нийт 51488 иргэнд тоон гарын үсэг олгож тоон гарын үсэг олгох ажил 57% -тай явагдаж, гүйцэтгэлийн төлөвлөгөө 100 хувь хэрэгжсэн.	100%

1.2	Иргэний бүртгэлийн дугаарыг хэрэглээнд нэвтрүүлж, шинэчилсэн загвар бүхий бэлдцэд бичилт хийх, хэвлэх	-	Шинэчилсэн загвараар иргэний үнэмлэх олгосон хувь	1	10	Засгийн газрын 2022 оны 374 дүгээр тогтоолоор иргэний үнэмлэхний тодорхойлолт, загварыг шинэчлэн баталсаны дагуу тус аймгийн хэмжээнд шинэчилсэн загвараар хэвлэгдэн ирсэн 6612 цахим иргэний үнэмлэхийг иргэдэд олгон төлөвлөгөөний биелэлтийг 100 хувь ханган ажиллаж байна.	100%
1.3	Бүртгэлийн үйлчилгээг мэдээллийн технологийн арга хэрэгслээр үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх	-	Улсын бүртгэлийн Цахим машин дахь үйлчилгээний тоо	22	50	Тус аймгийн хэмжээнд ашиглагдаж буй бүртгэлийн 3 цахим машинаас гарж буй иргэний улсын бүртгэлийн 12 төрлийн лавлагааг иргэд үнэ төлбөргүй авч байгаа бөгөөд, бүртгэлийн төрөл нэмэх хөгжүүлэлт хийгдсэн тохиолдолд шинэчлэлийг тухай бүрт татан авч ажиллаж байна.	100%
		-	Тоон гарын үсэг олгох бусад байгууллагын цахим /киоск/ машины тоо	2	3	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хөрөнгөөр шийдвэрлүүлсэн 53 600 000 төгрөгийн өртөг бүхий 2 ширхэг киоск машиныг иргэд харилцагчийн тоо хамгийн их байдаг төв ХААН банк буюу захын Төрийн банкны салбарт байршуулсан нь бүртгэлийн үйл ажиллагааг иргэдэд хүндрэл чирэгдэлгүй болж иргэд үйлчлүүлэгчдийн талархлыг хүлээж байна. Мөн Тус хэлтсийн Рэнчинлхүмбэ сумын улсын бүртгэгч П.Оргилсайхан нь сумын Засаг даргын тамгын газар болон ИТХ-ын төвлөрсөн орлогоос улсын бүртгэлийн киоск машины 26.800.000 /хорин зургаан сая найман зуун мянган/ төгрөгийг шийдвэрлүүлж, 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн сумын иргэддээ бүртгэлийн үйлчилгээг улам ойртуулан ажиллаж байна. "Төрийн үйлчилгээний цэг - Хаанаас ч	

							ойрхон” Хурдан цахим машины шинэчлэлт хийгдэж, тус хэлтэст байршуулсан киоск машинаас иргэд бүртгэлийн лавлагаа, тодорхойлолт тоон гарын үсэг авах болон 60 байгууллагын 600 гаруй үйлчилгээг авах боломж бүрдсэн.	
1.4	Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах, сурталчлах	-	-Баталсан дүрэм, журмын тоо, -Батлуулахаар хүргүүлсэн дүрэм, журмын тоо	4	4	4	-2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас зохион байгуулсан “Газрын багц хуулийн төслүүд болон Геодизи зураг зүйн тухай хуулийн төсөл, Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-д санал авах тухай хэлэлцүүлэгт оролцож холбогдох саналаа нэгтгэн хүргүүлсэн. -Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан Үндсэн хуулийн өөрчлөлтийн тухай хэлэлцүүлэгт 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хэлтсийн бүх албан хаагчид хамрагдан саналаа өгч, саналыг нэгтгэн УБЕГ-т хүргүүлсэн. -ЗГХЭГ-с 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээний журам”-ын төслийг танилцуулах, санал солилцох хэлэлцүүлэгт хэлтсийн албан хаагчид оролцсон. -ЭХЭУБТухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдөр санал хүргүүлсэн. -Гэр бүлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 09 дүгээр сарын 18-ны өдөр санал хүргүүлсэн. -Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-н сонгуулийн тухай хуулийн төсөлд 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр санал хүргүүлсэн.	100%

		-	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн сурталчилгааны тоо	378	500	Улсын бүртгэлийн хэлтсийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой болон бүртгэлийн чиглэлээр мөрдөн ажиллаж байгаа хууль тогтоомж, шийдвэрийн талаар зохион байгуулсан үйл ажиллагаа болон өдөр тутамдаа мөрдөн ажиллаж буй үйл ажиллагааны талаар цахим болон мэдээллийн самбарт 216 мэдээ мэдээллийг 761 удаагийн давтамжтай түгээн ажилласан. Мөн 23 сум 1 тосгоны улсын бүртгэгч нар өдөр тутмын үйл ажиллагаандаа болон сумын багийн өдөрлөгүүдээр хууль тогтоомжийг сурталчлан ажиллаж давхардсан тоогоор 4150 иргэнийг мэдээ мэдээллээр ханган ажилласан.	
1.5	Цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан иргэдийг мэдээ, мэдээллээр хангах, сурталчлан ажиллах	-	Цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэх талаар иргэдийг мэдээ мэдээллээр хангасан байдал, сурталчлан ажилласан тоо	-	10	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн “Үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам шинэчлэн батлах тухай” №71 дүгээр тогтоолын дагуу 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн үндэсний энгийн цахим гадаад паспортыг иргэдэд олгож эхэлсэн. Үүнтэй холбогдуулан тус хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуудсанд байршсан 12 удаагийн мэдээ мэдээллийг иргэдэд түгээн, хэлтсийн хэмжээнд цахим гадаад паспорт олгох ажлын нээлтийг “Хөвсгөлийн өнгө” цахим сувгаар шууд дамжуулан 3 удаагийн зурган мэдээлэл, 1 удаагийн видео бичлэгийг иргэдэд хүргэн хэлтсийн бүх албан хаагчид сумын болон бүртгэлийн цахим хуудсанд 308 удаагийн давтамжтай хуваалцан ажиллахаас гадна өдөр тутмын тутмын үйл ажиллагаандаа иргэдийг мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна. Цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлж, иргэдэд сурталчлан ажиллах	100%

							ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 6742 иргэнд цахим гадаад паспорт олгон ажилласан байна. Мөн Ханх, Тариалан, Түнэл, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Эрдэнэбулган, Цагаан-Уул, Төмөрбулаг сумдын иргэдэд Улсын бүртгэлийн үйлчилгээг ойртуулан 723 иргэний цаг хугацаа, санхүүг хэмнэн иргэддээ хүрч үйлчилсэн.	
Зорилт 2.Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.								
2.1	Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /E-mongolia, E-business/-аар үзүүлэх бүртгэлийн үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх	-	Нэмэгдсэн үйлчилгээний төрөл, тоо	90		105	Хэлтсийн албан хаагчид өөрсдийн facebook хуудсаар “E-Mongolia” системтэй холбоотой 10 мэдээ, мэдээллийг 116 удаагийн давтамжтай түгээн ажилласан. -Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3-т заасан нээлттэй мэдээллийг хэрхэн танилцах, хуулийн этгээдийн лавлагаа, хуулийн этгээдтэй эсэх талаарх лавлагааг хэрхэн цахимаар авах мөн E-Mongolia цахим системд хуулийн этгээдийн нэр баталгаажуулах, цахим гэрчилгээний талаар мэдээллийг иргэдэд цахимаар түгээн ажиллаж байна. -Тайлант хугацаанд төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэлийн les.e.business.mn системээр 680 хуулийн этгээдийн нэр баталгаажуулах хүсэлтийг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	100%
2.2	Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид	ADB төсөл	Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байгаа сум, хорооны тоо	2		10	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг сумынхаа иргэдэд хүргэх ажлыг Хатгал тосгоны улсын бүртгэгч М. Даваахүү, Цэцэрлэг сумын улсын бүртгэгч Д.Дэлгэрмөрөн нар хийж гүйцэтгэж байна. 2023 оны онд Улсын	100%

	үзүүлэх						<p>бүртгэгч Даваахүү нь нийт 252 бүртгэл хийснээс төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг анх удаа бүртгэх 45, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийг анх удаа бүртгэх 24, өмчлөх эрх шилжих гэрээний бүртгэл 14, барьцааны гэрээний бүртгэл 159, бүртгэлд өөрчлөлт оруулах бүртгэл 10-ийг тус тус бүртгэсэн байна.</p> <p>Цэцэрлэг сумын улсын бүртгэгч Д. Дэлгэрмөрөн нь нийт 52 бүртгэл хийснээс төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг анх удаа бүртгэх 9, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийг анх удаа бүртгэх 6, өмчлөх эрх шилжих гэрээний бүртгэл 8, барьцааны гэрээний бүртгэл 29-ыг тус тус бүртгэн мэдүүлэг нотлох баримтыг 7 хоног бүр хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт ирүүлж байна.</p> <p>Хэлтсийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Баянзүрх, Галт, Их-Уул, Тариалан, Улаан-Уул, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Шинэ-Идэр, Рашаант, Эрдэнэбулган сумын улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгох саналыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хүргүүлэн ажилласан. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар дээр Азийн хөгжлийн банкны /ADB/-ийн төсөл хэрэгжиж улсын бүртгэгч нарыг чадавхжуулах сургалтыг 2023.11.22-ны өдөр цахимаар зохион байгуулсан бөгөөд дээрх 10 сумын улсын бүртгэгч нарыг хамрууллаа. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрхийг 2023 ондоо багтаан нэмж 10, нийт 12</p>	
--	---------	--	--	--	--	--	--	--

							суманд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг хөтлөх эрх олгохоор бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
2.3	Нотариатч мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр хуулийн шаардлага хангасан мэдүүлэг, холбогдох баримт бичгийг улсын бүртгэлийн мэдээллийн санд илгээх, бүртгүүлэхэд зуучлах үйлчилгээг нэвтрүүлэх	-	“Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ”-г шинэчлэн байгуулсан нотариатчдын тоо	0		2	“Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ”-г шинэчлэн байгуулж, нотариатчид улсын бүртгэлийн мэдээллийн санд илгээж эхэлсэн ба Улсын бүртгэлийн ерөнхий газар дээр программын хөгжүүлэлт хийж, тестлэгдэж байгаа бөгөөд үйлчилгээг хэрэглээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг ханган байна.	100%
			Нотариатчаар зуучлуулан бүртгэсэн бүртгэлийн тоо	0		5		
2.4	Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх системийн хэрэглээ, цахим хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэх	-	Цахимаар бүртгүүлэхээр системд холбогдсон банк, санхүүгийн байгууллагын тоо	0		1	Улсын бүртгэлийн ерөнхий газраас барьцааны гэрээ, барьцааны гэрээнд орсон нэмэлт өөрчлөлт, барьцааны гэрээ дуусгавар болгох үйлчилгээг цахимаар эрхийн улсын бүртгэлд бүртгэх ажлыг үе шаттай зохион байгуулж байгаа ба энэ ажлын хүрээнд УБЕГ-ын даргын 2022 оны А/427 дугаар тушаалаар Барьцааны гэрээ /ипотек/-г эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт ЭУБ-06 маягт, барьцааны гэрээний нэмэлт өөрчлөлт/ипотек/-г улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт ЭУБ-13 маягтын загварыг шинээр баталж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх системийн хөгжүүлэлт хийгдэж байгаа бөгөөд бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	100%
			Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээний бүртгэлийн тоо	0		15		
			Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийн тоо	0		15		

2.5	Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан байгуулах, өөрчлөлт оруулах, хаягийн мэдээллийн сангийн нэглсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх	-	Газар, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн дундын мэдээллийн сан үүсгэж, өөрчлөлт оруулсан хувь	0		50	Хаягийн мэдээллийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх, газар үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх зорилтын хүрээнд улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь хаягийн мэдээллийг цэгцлэх, бичвэрийн зөрүүгүй болгох ажлыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд уг ажлын хүрээнд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэл зөвлөмжийг мөрдөн хэрэглээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
			Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн хувь	0		50		
2.6	Иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөх	-	Иргэний улсын бүртгэлийн тоо	31902		32000	Тайлант хугацаанд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 41834 бүртгэлийг хуульд заасны дагуу, хугацаанд нь хөтлөн ажилласан байна.	100%
			Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтөлсөн тоо	754		700	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 616 иргэн, хуулийн этгээдийн материал хүлээн авч бүртгэлийг хууль, тогтоомжийн дагуу хөтлөн ажилласан.	
			Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлсөн тоо	10338		10500	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх үл хөдлөх хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулж иргэнийг эдийн засгийн эрх чөлөөгөө эдлэх бүрэн боломжоор хангах зорилт тавин ажиллаж нийт 12391 мэдүүлэг хүлээн авч, холбогдох бүртгэлийг хуулийн дагуу хөтлөн ажиллалаа.	
2.7	Архивын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100		100	2023 оны архивын үйл ажиллагааны төлөвлөгөөг 9 арга хэмжээтэйгээр боловсруулан хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллалаа. Төлөвлөгөөний дагуу 2009 оноос 2018 онуудын хувийн хэрэг хаах материалыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар хувийн хэрэг хаах тухай	100%

	хангах						<p>тушаал гаргуулаагүй, нотлох баримтыг хувийн хэрэгт шууд хавсаргасан хаагдаагүй зөрчилтэй 42 мэдүүлэг нотлох баримтын судалгааг гаргаж Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлж, чиглэл авч ажиллан ХУБ-ын дүгнэлтээр ЭХЭУБГ-т хувийн хэрэг хаах тухай тушаал гаргуулж 33 хувийн хэрэг бүртгэлийг хаасан. Үлдсэн 9 мэдүүлгийн нотлох баримт дутуу байсан тул өмчлөгчтэй нь холбогдон, нотлох баримтаа бүрэн гүйцэт бүрдүүлэн ирж, хувийн хэрэг бүртгэлээ хаалгахыг мэдэгдсэн.</p> <p>2015 оноос хойш бүртгэгдсэн шинээр баригдсан орон сууцны бүртгэл болон, жагсаалтаар салж бүртгэгдэж байгаа орон сууцны бүртгэлүүдийг “EPRS2” цахим мэдээллийн сантай тулган шалгаж борлуулагдаж дууссан орон сууцны хувийн хэргийг хаах, дуусаагүй бол өмчлөх эрхийн гэрчилгээнд өөрчлөлтийн бүртгэл хийлгэхийг холбогдох иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэн ажиллаж 3 бүртгэлд хэмжээ өөрчлөх бүртгэлийг хийсэн. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн сангаас алгасаж унасан дугаарын жагсаалтыг гарган Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлэн ажиллалаа.</p> <p>Байгууллагын иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн архивын хадгалах хугацаа дууссан баримтуудыг байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлэн батлуулж 2023.03.24-ний өдөр акт үйлдэн устгасан. ИГГБББ-ийн дэвтрүүдийг нэг бүрчлэн тоолж, сэлбэн засах хаягийг шинэчлэсэн. Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн архивын заагуурыг шинэчлэн тавиурын эгнээ тус бүр дээр байрлууллаа.</p>	
--	--------	--	--	--	--	--	---	--

							Мөн галын булан, галын хорыг шинэчилсэн. Хуулийн этгээдийн архивын тооллого хийх ажлын хэсэг байгуулан ажиллаж, хувийн хэргийг 100 хувь тоолж дуусган, хавтсыг сэргээн засаж, хаягийг шинэчилж, архивын үйл ажиллагааны төлөвлөгөө 100 хувь хэрэгжсэн.	
2.8	Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд хил нэвтрэх үнэмлэхийн бүртгэлийг хөтлөх.	-	Хил нэвтрэх үнэмлэхийн бүртгэл хөтөлсөн тоо	0		700	Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд хил нэвтрэх үнэмлэхийн бүртгэлийг хөтлөх эрхийг нээлгэж бүртгэл хөтлөх үйл ажиллагааг тестлэж үзсэн боловч, програмын тохиргоо таарахгүй байгаагаас шалтгаалан хуучин загварын дагуу хил зорчих үнэмлэхийг хэвийн олгож байна. Тайлант хугацаанд хил орчмын нутаг дэвсгэрт хялбаршуулсан журмаар зорчих үнэмлэх 2155 ширхэгийг бүртгэж, иргэдэд олгосон байна.	100%
2.9	Байгууллагаас сар бүр үзүүлсэн үйлчилгээний талаар инфографик мэдээлэл бэлтгэх, олон нийтэд хүргэх	-	Сар бүр иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээний талаарх инфографик мэдээллийг бэлтгэн брошур хэлбэрээр байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан тоо;	12		12	Тус хэлтсийн 1-11 дүгээр сарын иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээний талаар 1 удаагийн инфографик мэдээллийг үнэн зөв гарган тус, хэлтсийн цахим хуудас болон хэлтсийн ил тод байдлын самбар, олон нийтийн сүлжээнд байршуулан, хэлтсийн албан хаагчид 49 цахим хуудсанд 215 удаагийн давтамжтай түгээн ажиллаж байна.	100%
2.10	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэх, түүнд хяналт тавих ажлыг сайжруулах.	-	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн хувь	100		100	-Тайлант хугацаанд хэлтсийн хэмжээнд иргэдээс 122 өргөдөл, гомдол хүлээн авж 97.5% шийдвэрлэсэн бөгөөд 1,2,3 дугаар улирлын өргөдөл гомдлын мэдээг УБЕГ-т хугацаа хоцроолгүй үнэн зөв хүргүүлэн ажиллаж байна. -Иргэдээс хүлээн авсан 122 өргөдөл гомдлоос иргэний улсын бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой 44 өргөдөл, эд хөрөнгийн эрхийн улсын	100%

							<p>бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой 5 өргөдөл, бүртгэлийн хяналтын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 59 өргөдөл, албан хаагчтай холбоотой гомдол 2, хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой 3 өргөдөл, 9 хүсэлт нийт 111 өргөдөл, 9 хүсэлт, 2 гомдол хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн 3 өргөдлийн хугацаа болоогүй хүлээгдэж байна.</p> <p>-Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд тус хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч өдөр тутамдаа хяналт тавин ажиллаж байна.</p>	
2.11	Хэлтсийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулан, гүйцэтгэлийн тайланг заасан хугацаанд нь тайлагнах	-	Хэлтсийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулан, гүйцэтгэлийг биелүүлсэн хувь	90.2		95	<p>Хэлтсийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 29 арга хэмжээтэйгээр боловсруулан, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар батлуулан, 2023 оны жилийн эцэст хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 29 арга хэмжээг хяналтандаа авч хэрэгжилтийг 100% ханган ажиллаж байна. Мөн нэмэлтээр хэлтсийн барилгын их засварын ажлыг гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган, хэрэгжилт 100 хувь биелсэн.</p>	100%
2.12	Гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид үзүүлэх	-	Гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж буй сумын тоо	-		10	<p>-Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийг анхан шатны нэгжээс үзүүлэх ажлын хүрээнд аймгийн төвөөс хол, алслагдсан Тариалан, Цагаан-Уул, Цэцэрлэг, Их-Уул сумдад нэвтрүүлэхээр нийт 12.140.000 төгрөгийн төсвийг сумын ИТХ-р шийдвэрлүүлэн, гадаад паспортын бүртгэл хөтлөх тоног төхөөрөмж /зургийн аппарат, гэрэлтүүлэгч иж бүрэн, хөшиг/ болон үйлчилгээний хураамж төлөх гэрэгэ пос төхөөрөмжийг худалдан авсан.</p>	70%

							Тус сумдын улсын бүртгэгч нарыг хэлтэст дадлага хийлгэж, гадаад паспортын бүртгэлийг хөтлөх эрхийг нээлгэх албан бичгийг УБЕГ-т хүргүүлэн, гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг 4 суманд үзүүлэх боломж бүрдэж байна.	
Зорилт 3.Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.								
3.1	Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах	-	Эрсдэлийн төлөвлөгөөний биелэлт, хувиар	-		100	<p>-Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нийт шилжилт хөдөлгөөний 709 бүртгэлийн нотлох баримтыг шалгаж, үнэн зөв бүртгэгдэж, баталгаажсан эсэхэд хяналт тавьж ажиллахад ямар нэг алдаа зарчил илрээгүй болно.</p> <p>-Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын ахлах бүртгэгч нь нийт улсын бүртгэгч нарыг мэргэжил арга зүйгээр тогтмол ханган ажиллаж 2023 онд 41834 иргэнд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг үнэн зөв хүргэн ажилласан байна.</p> <p>-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн улсын ахлах бүртгэгч нь бүртгэлийн болон мэдээллийн сангийн үнэн зөв байдлыг хангах, улсын бүртгэгч нарыг аливаа эрсдэл, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлсөн мэдүүлэг, нотлох баримтуудыг өдөр бүр мэдээллийн сантай тулган шалгаж байна. 2023 онд 12391 бүртгэлийг шалгасан.</p> <p>-Хэлтсийн албан хаагчдыг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2022 онд Дотоод хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа бөгөөд уг ажлын хэсэг 2023 оны төлөвлөгөөний дагуу 3 удаагийн хяналт шалгалт хийж үр дүнг тооцон ажилласан.</p> <p>-Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны</p>	100%

							эрсдлийг буруулах ажлын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилго бүхий сургалтыг Хэлтсийн дарга, Хяналтын улсын байцаагч нар Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хамтын ажиллагаа, сургалтын хэлтсээс ирүүлсэн хөтөлбөрийн дагуу 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч нарт танхимаар зохион байгууллаа.	
3.2	Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг үнэлж, дүгнэлт гарган, мэдээллийн санг цэгцлэх	-	Төлөвлөгөөний хэрэгжилт хувиар	-		100	Улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газрын эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 7 хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хийж хэрэгжүүлэн илтгэх хуудсыг хүргүүлсэн. Мөн 13 чиглэл зөвлөмжийг улсын бүртгэгч нарт тухай бүр танилцуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. 2023 онд хяналтын улсын ахлах байцаагчийн 1500 дугаар дүгнэлт болон нэгжийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үндэслэн мэдээллийн санд алдаатай бүртгэгдсэн нийт 120 бүртгэлд засвар өөрчлөлт оруулсан байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн “Мэдээллийн сан цэгцлэх тухай” иргэний улсын бүртгэлийн санд нөхөн шивэлтээр бүртгэсэн төлөвтэй болон хоёр удаа нөхөн шивэлтээр бүртгэсэн 22 иргэний мэдээллийг шалгаж дараах ажлыг хийж гүйцэтгэж ажиллалаа. Үүрэг чиглэлд заасан хугацаанд өөрийн харъяалах нэгжид бүртгэгдсэн бүртгэлийн жагсаалтыг мэдээллийн санд шалгаж, Иргэний улсын бүртгэлийг цахимжуулсан материалыг харах, ашиглах, засварлах программ хангамжаас бүрэн цахимжсан мөн нөхөн шивэлтээр бүртгэсэн, хоёр	100%

							удаа санд орсон эсэхийг тус тус нотлох баримттай тулган шалгалаа. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд давхар бүртгэсэн 6 иргэний мэдээлэл бүртгэсэн төлөвтэй байна. Иймд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд зөрчлийг арилгах зорилгоор нэр бүхий 16 бүртгэлд хоёр удаа нөхөн шивэлтээр бүртгэсэн давхар бүртгэлийг Хяналтын улсын байцаагчийн 2023 оны 10 дугаар сарын 10 ны өдрийн №6199 дугаартай дүгнэлт гаргаж бүртгэлийг хүчингүй болгуулахаар иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүсэн. 6 иргэнийг гэрлэсний бүртгэл, гэрлэлт дуусгавар болсны бүртгэлд нөхөн шивэлтээр бүртгэсэн төлөвтэй бүртгэлийг дахин шалгаж баталгаажуулан ажиллалаа. Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн жагсаалтын дагуу 2006-2018 онд төрсөн 50 хүүхдийн ургийн овгийг мэдээллийн санд нэмэлт өөрчлөлтөөр оруулж зөрчил арилган ажилласан байна.	
3.3	Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих замаар улсын бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг хангах	-	Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	2023 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө болон ажлын байрны тодорхойлолтонд заагдсан Улсын бүртгэл, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, илэрсэн зөрчлийг арилгуулах, улсын бүртгэлийн ажилтны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих чиг үүргийн дагуу 3211 бүртгэлд хяналт тавьж ажилласнаас Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-2625, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр-254, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр-137, Улсын бүртгэлийн	100%	

						архивын чиглэлээр-195 тус тус шалгаж ажиллалаа. Шалгалтын явцад нийт 174 зөрчил илэрсэн бөгөөд Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-104, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр-64, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр-6, тус тус зөрчил илэрсэнийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр арилган ажилласан.
		Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн тоо	169		50	Зөрчлийн хуулиар 25 иргэн, хуулийн этгээдэд торгууль оногдуулсан бөгөөд торгууль оногдуулсан хүн-23, торгууль оногдуулсан хуулийн этгээд-2 торгууль, шийтгэх хуудас бичиж Төрийн сангийн торгууль, хүү төвлөрүүлэх дансанд 1460000 төгрөгийн орлого төвлөрүүлсэн.
		Дотоод хяналт, шалгалтын ажлын хэсгийн шалгалтын тоо	1		2	-Тус хэлтсийн дотоод хяналт шалгалтын ажлын хэсэг нь 2023 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж 2023 оны 1 дүгээр сары 30-ны өдөр хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу хэлтсийн албан хаагчдыг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах хяналт шалгалтуудыг хийж гүйцэтгэлээ. -Иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2023 оны 1,2,3 дугаар улиралд бүртгэсэн бүртгэлүүдийг үнэн зөв, хууль тогтоомжид нийцсэн эсэхийг түүвэрчилсэн байдлаар шалгалаа. -Шалгалтаар хууль дүрэм зөрчсөн ноцтой алдаа дутагдал илрээгүй бөгөөд улсын бүртгэгч нарын хайхрамжгүй байдлаас цахимжуулалтын жижиг алдаа гаргасныг улсын бүртгэгч нараар тухай бүр засуулан зөрчлийг арилгаж ажиллалаа. -Байгууллагын тоног төхөөрөмж, цахим мэдээллийн сангийн аюулгүй байдал, нууцлал, тог цахилгааны аюулгүй

							<p>байдлыг хэрхэн хангаж ажилладаг талаар шалгахад компьютер тоног төхөөрөмжийг цахилгааны эх үүсвэрээс салгахгүй явах, компьютер тоног төхөөрөмжөө унтраахгүй орхих зэрэг зөрчил дутагдал илэрснийг албан хаагчдад анхааруулж, дахин ийм зөрчил дутагдал гаргахгүй ажиллахыг сануулсан байна.</p> <p>-Нярав-Бичиг хэргийн ажилтны өдөр тутмын ажлыг шалгаж заавар зөвлөгөө өгч ажилласан. Шилэн дансны мэдээлэл хугацаандаа үнэн зөв орсон эсэхэд хяналт шалгалт хийхэд ямар нэгэн зөрчил илрээгүй болно. Албан хаагчдын ажлын цаг ашиглалт, үйлчилгээний стандарт, хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг өдөр тутамдаа шалган ажиллаж байна.</p>	
3.4	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах, тайлагнах, байршуулах, санхүүгийн дотоод аудитыг хэрэгжүүлэх	-	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хувь.	100		100	Шилэн дансны хуулийн хэрэгжилт 100 хувьтай хангагдан, мэдээ мэдээлэл хуулийн хугацаанд байршиж байна.	
			Тайлагнаж байршуулсан мэдээллийн тоо	133		175	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг зүй зохистой зарцуулах, тайлагнах шилэн дансанд мэдээллийг байршуулах ажлын хүрээнд 175 мэдээ мэдээлэл байршихаас 138 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулан ажилласан.	
3.5	Аймгийн аудитын газар болон бусад байгууллагаас ирүүлсэн зөвлөмжид хяналт тавих, мэдээ мэдээлэл,	-	Зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийн хувь	80		100	Тус хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар "ЗӨРЧИЛГҮЙ" санал дүгнэлт авч УБЕГазарт нэгтгүүлж, тайлантай холбоотой бүхий л мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь гарган өгч Аймгийн Аудитын газартай хамтран ажилласан. Тус хугацаанд санхүүтэй	100%

	тайланг хугацаанд нь хүргүүлэх						холбоотой зөвлөмж, акт, албан шаардлага аваагүй бөгөөд төлөвлөгөөний биелэлтийг 100 хувь ханган ажиллаж байна.	
3.6	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын баримтад тооллого хийх	-	Тооллого хийсэн хувь	-		100	2023 оны хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заасны дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивыг тоолох ажлыг Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2023 оны 04 дүгээр сарын 03-ний өдрийн А/02 дугаар “Тооллогын комисс томилох тухай” тушаалын дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын баримтад тооллого хийх ажлыг зохион байгуулж архивт цахим санд бүртгэлтэй 3035, татан буугдсан 325 шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 135 нийт 3495 хуулийн этгээдийн хувийн хэргийн эх нотлох баримтыг цахим сантай тулган алдааг арилгах, цахимжуулах ажлыг 100%-ийн гүйцэтгэлтэй хийж гүйцэтгэлээ.	100%
3.7	Хөндлөнгийн төрийн бус байгууллагатай хамтран хэрэглэгчийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах	-	Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэсэн тоо	-		1	Тус хэлтэс нь “Хөвсгөлийн Хөгжил дэвшилд” төрийн бус байгууллагаар 2023 оны 11 дүгээр сард 44 албан хаагч, 51 иргэн, Цагдаагийн газар, ШШГГ, Шүүхийн байгууллага болон, орчны ажиглалт гэсэн 4 үндсэн төрлөөр хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, үнэлгээний тайланг хүлээн авлаа. Үнэлгээгээр тус хэлтсийн давуу тал: -Иргэдэд үйлчлэх цахим үйлчилгээг нэмэгдүүлж цаг завьг хэмнэсэн иргэдэд цахим машиныг ашиглах зааврыг байршуулсан -Албан хаагчид ажилдаа идэвх санаачлагатай иргэдэд үйлчилгээ үзүүлэхдээ эерэг хандлагатай байсан -Иргэд бүртгэлийн үйлчилгээ авахад бүрдүүлэх материалын хөтөч дэвтэр ойлгомжтой байсан. Сул тал:	100%

							-Хэлтсийн албан хаагчдын ахлах нягтлан бодогч, мэдээлэл технологийн ажилтан нарын тоног төхөөрөмж шинэчлэх шаардлагатай -Төрийн албан хаагчтай иргэд зүй бусаар харьцах, дайрч доромжлох, үйлдэл гаргахгүй байхаас сэргийлэн хууль эрх зүйн санамж байршуулах. -Орон нутгийн албан хаагчдад томилолтын зардал төсөвт суугаагүй зэрэг болно.	
3.8	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивт архивын тавиурыг шинээр нэмэгдүүлэх		Шинээр байрлуулсан архивын тавиурын тоо	5		1	Тус хэлтэс нь архивын зориулалтын 3 тавиурыг иргэний баримтын архив, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архив, хуулийн этгээдийн архивт тус тус нэмж байрлуулаад байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивт тавиур нэмэгдсэнтэй холбогдуулан архивын заагуурыг шинэчилсэн ба галын хор, галын буланг шинээр хийн байршууллаа.	
Зорилт 4. Орон нутагтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.								
4.1	Аймгийн ЗДТГ-ын “Хууль эрх зүйн” хэлтэс, ГХБХБГ, ГБХЗХГ-тай хамтран ажиллах	-	Хамтран зохион байгуулсан ажлын тоо	16		20	-Аймгийн ГХБХБГазар, ШШГГазар, тойргийн нотариатууд, Татварын хэлтэс, Сумдын тамгын газрын дарга нартай тогтмол мэдээлэл солилцож хамтран ажилласан. -2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Аймгийн ГХБХБГ-с зохион байгуулсан “Газрын багц хуулийн төслүүд болон Геодези, зураг зүйн тухай хуулийн төсөл, Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-д санал авах тухай хэлэлцүүлэгт санал өгсөн. -2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Монголын хуульчдын холбоо, Аймгийн ЗДТГ-ын санаачлан зохион байгуулсан Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хамтарсан “Бидний үйл	100%

							<p>ажиллагаа-Таны нүдээр” нээлттэй хаалганы өдөрлөгт оролцсон.</p> <p>-2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Аймгийн засаг даргын тамгын газрын Хууль-эрх зүйн хэлтэстэй хамтран зохион байгуулсан “Төрийн байгууллагын албан хаагчдын сахилга, ёс зүйн нэгдсэн зөвлөгөөн”-д оролцлоо.</p> <p>-2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр аймгийн Хууль эрх зүйн хэлтсийн “Нэгдье” аянд нэгдсэн.</p> <p>-ГБХЗХГ, Мөрөн, Тариалан, Ханх, Шинэ-Идэр, Жаргалант сумын ЗДТГ-тай хамтран 6 удаагийн “Гэрлэлтийн андгай” өргөх ёслолыг зохион байгуулж Мөрөн сумын Иргэний гэр бүлийн 8н төрлийн бүртгэл хөтлөх өрөөг бүрэн тохижуулсан.</p> <p>-Аймгийн Төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран 4 удаагийн ТАХ-н ерөнхий шалгалтыг зохион байгуулсан.</p> <p>-Аймгийн ЗДТГ-тай хамтран 15 суманд бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн 723 иргэнд үндэсний энгийн цахим гадаад паспорт олгож, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 272 иргэнд мэдээлэл өгж, 86 иргэнд гэрчилгээ олгосон. Мөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 53 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгж, 11 бүртгэл бүртгэж, гэрчилгээ олгосон.</p>
--	--	--	--	--	--	--	---

Зорилт 5. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.

5.1	Хэлтсийн 2023 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	-	Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	Хэлтэст зохион байгуулах 2023 оны сургалтын төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр боловсруулж хэлтсийн даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу холбогдох сургалтанд хамрагдаж байгаа бөгөөд тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 19, Улсын бүртгэлийн ерөнхий газраас болон аймгийн ЗДТГ, бусад байгууллагаас зохион байгуулсан нийт 49 удаагийн сургалтад хэлтсийн бүх албан хаагчид болон хэлтсийн дарга, холбогдох албан хаагчид бүрэн хамрагдсан байна. Мөн аймгийн Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучууд хөгжлийн газар, Хүний эрхийн үндэсний комисс, Тагнуулын байгууллагын сургалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтыг хэлтсийн албан хаагчдад танхимаар зохион байгуулж, сургалтын төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай хангагдан ажиллаж байна.	100%
5.2	Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системийг хэрэглээнд бүрэн нэвтрүүлэх, хуульд заасны дагуу холбогдох мэдээллийг цахим хуудаст байршуулах	-	Цахим сургалтын мэдээллийн баяжилтыг хийсэн хувь	60	100	Цахим сургалтын системийг албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байгаа бөгөөд Хэлтсийн төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний 41 албан хаагч сургалтын программд байршсан бүх хичээлийг бие даан судалж, нийт 38 албан хаагч 17 чиглэлийн шалгалтыг амжилттай өгсөн. Шалгалтад оролцоогүй 3 албан хаагчийн хүний нөөц сургалтын программын хичээл нээгдэхгүй болон шалгалтын дүн харагдахгүй байсныг Хамтын ажиллагаа сургалтын хэлтэст мэдэгдэж програмын эрхийн тохиргоо хийлгэхээр хүсэлтээ хүргүүлсэн.	100%
5.3	Архивчдын нэгдсэн	-	Сургалт зохион байгуулсан тоо			Тус хэлтсийн иргэний баримтын архивч Б.Оюунцэрэн, эд хөрөнгө, хуулийн	

	сургалтыг зохион байгуулах			0		1	<p>этгээдийн баримтын архивч Д.Пүрэвсүрэн, бичиг хэргийн эрхлэгч Б.Содномцэрэн нар нь Аймгийн Засаг даргын тамгын газрын Архивын тасгаас зохион байгуулсан “Анхан шатны архив нь төр, түмний түүхийн эх сурвалж” сарын аяны хүрээнд зохион байгуулагдсан Архивын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2 өдрийн сургалтад хамрагдсан.</p> <p>Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулахаар төлөвлөгдсөн байсан сургалт нь Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд хойшлогдсон бөгөөд, сургалт зохион байгуулагдах цаг хугацаанд албан хаагчдыг бүрэн хамруулан ажиллах болно.</p>	100%
Зорилт 6. Нэмэлт арга хэмжээ								
6.1	Хэлтсийн барилгын засварын гүйцэтгэх их ажлыг	478.0	Хэлтсийн барилгад их засвар хийж гүйцэтгэсэн байдал			1	<p>Тус хэлтсийн барилгын их засварын төсвийг шийдвэрлүүлэхээр Хууль зүйн сайд Х.Нямбаатарт албан бичиг хүргүүлснээр засварын төсөв болох 478.000.000 /дөрвөн зуун далан найман сая/ төгрөгийг шийдвэрлүүлэн ажиллалаа. Тус хэлтсийн барилгын их засварын ажлыг хийж гүйцэтгэх байгууллагын тендерийн үйл ажиллагаа Улсын бүртгэлийн ерөнхий газарт зарлагдан “Өгөөмөр Уул” ХХК шалгарч барилгын инженерийн шугам сүлжээ, дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж, халаалт, агаар сэлгэлт болон бусад засварын ажлыг 2023 оны 06 дугаар сарын 18-ны өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн хооронд гүйцэтгэж, тус хэлтэст хүлээлгэж өгсөн бөгөөд хэлтсийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа бүрэн хангагдаад байна.</p>	100%

6.2	Хэлтсийн ажиллагааг шинэлэг байдлаар сурталчлан ажиллах үйл	1.500	Хэлтсийн ажиллагааг иргэдэд сурталчилсан байдал		1	<p>-Тус хэлтэс нь “Эрхэм төрийн алба” хэмээх байгууллагын сүлд дууг бүтээн дүрсжүүллээ. Уг дууны үгийг “Ханх сумын улсын бүртгэгч Р. Нэргүй бичиж, аяыг Б. Хангай зохиосон ба дуучин И. Наранзаяагаар дуулуулсан. Дуу бүтээхэд гарсан холбогдох зардлыг хэлтсийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд тарьж ургуулсан төмсний ашгаас шийдвэрлэсэн.</p> <p>-Мөн манай хамт олноос гаргасан шинэ, шинэлэг санаачлагаар “Бүртгэлхүү, Бүртгэлмаа” нэртэй контентыг эхлүүлсэн бөгөөд эхний контентыг “Тоон гарын үсэг” сэдвээр бүтээж цахим хуудсанд байршуулаад байна. Энэхүү контент нь бүртгэл тус бүрээр цаашид үргэлжлэх бөгөөд шинэ контентыг тухай бүр цахим хуудаснаа байршуулан бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлан ажиллахаар төлөвлөж байна.</p> <p>-Тус хэлтсийн иргэний гэр бүлийн 8 төрлийн бүртгэлийн 101 тоот өрөөг Аймгийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран тохижуулж, иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлэхэд эерэг таатай орчинг бүрдүүлэн ажиллалаа.</p>	100%
-----	---	-------	---	--	---	---	------

Төлөвлөгөөг үнэлсэн:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга
(албан тушаал)

Төсвийн шууд захирагч

.....
(гарын үсэг)

/Д.Дэлгэрсайхан/

2023.11.27

Тэмдэг

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

Нэгжийн дарга

Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газрын дарга
(албан тушаал)

.....
(гарын үсэг)
2023.11.27
Тэмдэг

/Т.Гантөмөр/

Тайлагнасан:

Нэгжийн дарга

Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
(албан тушаал)

.....
(гарын үсэг)
2023.11.27
Тэмдэг

/Б.Мөнгөнзул/